

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны 04 дүгээр сарын мэдээлэл

2023.04.24.

“Овоот”

**Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.**

-2023.04.07 нд сумын нийт төсвийн байгууллагуудын удирдлагын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж дараахь чиглэлээр хэлэлцэж, үүрэг даалгавар өгсөн.

а/. Алтан дарь овооны 110 жилийн ой угтсан ажил

б/. “Эрүүл аюулгүй ажлын байр бидний суурь эрх” аяны хүрээнд хийх ажил

в/. “Хүүхэд хөгжил хамгааллыг дэмжих жил” ийн хүрээнд хийх ажил

г/. “Энэ жилдээ-эрүүл жиндээ” аяны хүрээнд хийгдэх ажил

д/. “Авлигатай тэмцэх жил-2023” арга хэмжээний хүрээнд хийх ажил

е/. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийх ажил

ё/. 1 дүгээр улиралд хийгдсэн онцлог ажил үйлчилгээний талаар товч мэдээллийг төрийн байгууллагуудын удирдлагууд танилцуулсан.

Сумын Засаг даргын 2023.04.14 ний өдрийн А/30 дугаар захирамжаар “Авлигатай тэмцэх жил-2023” арга хэмжээний хүрээнд ажиллах комиссыг томилсон.

Дээрх комисс 5 ш ажиллагааны дагуу “Шүүр” арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд Авлигатай тэмцэх газрын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Хяналт шалгалт хийлгэх тухай” 05/4742 тоот албан бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Соёлын төвийн 2020-2023 оны санхүү төсөв, хүний нөөц, үйл ажиллагаанд аймгийн ажлын хэсэг 6 хүний бүрэлдэхүүнтэй 3 хоног ажилласан.

**-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр**

Хөдөөгийн 4 багт багийн Засаг дарга нараар ахлуулсан ажлын хэсэг 10 хоногт “гэрээр зочлох” хэлбэрээр очиж төрийн үйлчилгээ үзүүлж, цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, хээрийн болон ахуйн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага тарааж, малчдын санал хүсэлтийг сонсох ажиллагааг зохион байгууллаа.

**Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

Монгол улсын засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогоолоор 2023-2025 оныг монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан орчны бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэх зорилгоор БОАЖСайдын Эрүүл аюулгүй цэвэр орчин бүрдүүлэх тухай 2023 оны 02 дугаар албан даалгавар, сумын засаг даргын 2023 оны 03-р сарын 28 ны өдрийн А/24 дүгээр захирамжаар ажлын хэсэг томилон

сумын төвийн ойролцоо болон уст цэгүүдийн сэг зэм устгалын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нийт 4 удаагийн цэвэрлэгээгээр нийт үхэр 292, адуу 18, тэмээ 3, хонь 30 устгаад байна. Тус ажилд ЗДТГазар, БЦГХЗахиргааны 3 машин давхардсан тоогоор 53 албан хаагч хамрагдан ажилласан. ДТ-290л, АИ92-80л, 400,000 төгрөг зарцуулсан байна.

### **Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

ЕБС: 2023.04.10-04.14. "Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах" БЕГ, БШУГ-тай хамтарсан зөвлөн туслах үйл ажиллагааны баг 2023 оны 04 сарын 10-14-ний өдрүүдэд ажиллалаа.

1. Багш нарын хичээлд ажиглалт хийх
2. Сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийх
3. Сайжруулсан хичээл зохион байгуулах
4. Үзүүлэх хичээл
5. Хамтарсан хичээл
6. Сургуулийн бодлогын бичиг баримт, сургууль хөгжүүлэх хөтөлбөртэй танилцаж зөвлөн туслах
7. Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш, сурагчидтай фокус бүлгийн ярилцлага хийх
8. Сургалтын гадаад, дотоод орчинтой танилцах
9. Мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажилд зөвлөн туслах
10. Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийж сургуулийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл байдлыг илрүүлэн цаашид сайжруулан ажиллах саналыг хамтран боловсруулж байна.

-ХАБЭА-н сарын аяны хүрээнд БШУГ-ын мэргэжилтэн С.Батбаяраар сургууль, дотуур байрынхаа гадаад, дотоод орчинд эрсдэлийн үнэлгээ хийлгэн хамтран ажиллалаа. Эрсдэл болоод зөрчлийг 14 хоногийн хугацаанд арилгахаар бэлтгэл ажилдаа орлоо.

-“ӨГЛӨӨГ ӨӨРТӨӨ” арга хэмжээг өглөө бүр зохион байгуулж нийт ажилтан албан хаагчид дасгал хөдөлгөөнийг хэвшүүлж байна.

ЦЭЦЭРЛЭГ: Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ-г 2023.04.17-21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж байна.

УБ хотын шүдний эмч байгууллагын эмчтэй хамтран хүүхдийн шүдний өвчлөл ба эрүүл ахуй сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Үүнд 6 бүлгийн туслах багш нар хамрагдлаа. Мөн 6 бүлгийн 165 хүүхдийг шүдний үзлэгийг хийж эмчилгээнд явах хүүхдийг дараа дараагын шат дараатай арга хэмжээ авахаар боллоо.

Хөдөлмөрийн апулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд байгууллагын 3 тогооч, 2 үйлчлэгч, нярав нарыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл мөн угаалга цэвэрлэгээ, ариутгалын бодис зэргээр хангаж ажиллаа. Угаалга цэвэрлэгээ үйлчилгээний бодист 465000 мянг төгрөг, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлд 445,000 мянган төгрөг нийт 910,000 санхүүжилт зарцуулсан

ЭНЭ ЖИЛДЭЭ-ЭРҮҮЛ ЖИНДЭЭ аяны хүрээнд "[Өөхөө тушаая](#)" идэвхитэй дасгал хөдөлгөөнийг 2023.03.21 нээс эхлэн 1 сарын хугацаатай ажлын байран дээрээ өрнүүлж 10 дахь хоногтоо урьдчилсан жин хэмжилт /1-4кг жин хассан 🥰🥰/, эрүүл зөв хооллолт, 🍏🍏 [#Алимны удааатай](#) зөвлөгөөг өгч амжилттай үргэлжилж байна.

### **Дөрөв. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Сумын ахмадууд нь идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж сар бүрийн 5,15,25 -ний өдрүүдэд нийтийн бүжиг зохион байгуулдаг сайн дадал хэвшилтэй билээ .

Энэ удаад эрүүл мэндийн төв нь ахмадын дөрөвдүгээр бүлэгтэй хамтран [#Энэ\\_жилдээ\\_эрүүл\\_жиндээ](#) аяны хүрээнд хэсэгхэн ч болов цаг хугацааг авхаалж самбаатай, хөгжилтэй өнгөрүүлэх зорилгоор 60 гаруй ахмадыг хамруулсан 4 төрөлт буухиа, олс таталтын тэмцээнд зохион байгууллаа. Мөн Ахмадын биеийн жингийн индекс тодорхойлох , артерийн даралт хянах үйл ажиллагааг явуулсан .

Өвөлжилт хүндэрч , хаваржилтийн цаг агаарын нөхцөл байдал амаргүй байгаа энэ цаг үеүүдэд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэх зорилгоор багийн эмч нар тодорхой маршрутын дагуу 2023.04 сарын 17 өдрийн байдлаар 2,3 -р багийн 181 иргэнд хүрч ажиллаад байна

Эрүүл мэндийн байгууллагын "ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТ- 2023 " бүсийн сургалтанд хамрагдсан Ахлах сувилагч ,ХСХ багийн гишүүн Б.Болормаа эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдад дотоодын сургалтыг явууллаа.

### **Тав. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

Сумын засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 20 ны өдрийн А/31 тоот захирамжийн хүрээнд “ШИЛДЭГ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ-ЖИШИГ ГУДАМЖ” шалгаруулах болзолт уралдааныг зарлаад байна.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/77 тушаал, аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн онцгой байдлын албатай хамтран аялал жуулчлалын бүс нутаг “ Шилийн богд”-ын орчимд эргүүлийн постыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж байна. Эргүүлийн пост 4-р сарын 01 нээс 5-р сарын 01 ны хугацаанд ажиллана.

Өнөөгийн байдлаар “Шилийн богд”-ын ойр орчинд нутаглаж байгаа 54 малчин өрхийн 184 иргэнд хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа 3 төрлийн 500 ш гарын авлага материалыг олгож зөвлөн, туслах үйлчилгээг үзүүлээд байна.

Улаанбаатар хотоос “Шилийн богд” уулыг зорин аялагч, зорчигч 25 тээврийн хэрэгслэл, 102 зорчигчид 85 ш гарын авлага материалыг олгосон.

Хамгаалалтын захиргаанаас Нартын ууланд нутаглаж байгаа аргаль хонинд ажиглалт мониторингийн судалгааг хийж 36 аргаль хонь хурга тооллоо. Мөн аргаль хонины идээшилдэг 2 цэгт 8 боодол өвс тавьж, хөдөлгөөн мэдрэгч камер байршууллаа.

ЗЭх дэлхийн өдөр”-т зориулж сургуулийн ЭКО клубын сурагчдад экологийн боловсрол олгох, байгаль хамгаалах “ Нүүдэлчин хайрцаг ” хичээлээр хээрийн сургалт зохион байгууллаа.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР